



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 5/22

Чингис хот

С.Галбадрахыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.2.2, 9.2.3 дахь заалт, Засгийн газрын 1999 оны "Цэргийн цолны цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 38 дугаар тогтоол, 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Б/52 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хошууч Сүлдийн Галбадрахыг Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалт эрхэлсэн офицероор 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч

Н.Хүрэлээ

Цэргийн штабын дарга

Гишүүд

Т.Бямбадулам

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа

Нярав

3. Хошууч С.Галбадрахын цалинг ТТ-13-5 шатлалаар тогтоон үндсэн цалин 951344 /есөн зуун тавин нэгэн мянга гурван зуун дөчин дөрөв/ төгрөгөөр, цэргийн цолны цалинг 32, удаан жил ажилласны нэмэгдлийг 15, онцгой нөхцөлийн нэмэгдлийг 10 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д зөвшөөрсүгэй.

4. Хошууч С.Галбадрахад томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР